



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын II цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/003НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор: Д.Нарантуул Утас:99019800 Цахим хаяг: ntuul9800@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2026.02.13 № 84

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БУЛГАН СУМЫН II ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Б.ОЮУНДЭЛГЭР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын II цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Булган сумын II цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Амралт цалин ур чадварын нэмэгдэл, орон нутагт ажилласны нэмэгдлийг тогтоолд заасан хувиас илүү олгосон 6.2 сая төгрөг,
- Дотоод хяналтгүйгээс Боловсрол мэдээллийн esis.edu.mn систем дэх хүүхдийн ирцийн цахим бүртгэл багш нарын журнал дахь бүртгэл зөрүүтэй, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан зөрүүтэй тайлагнасантай холбоотой 9.4 сая төгрөг зэрэг алдаа, зөрчлүүд байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6.дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг

баталгаажуулах; ажилтан хариуцна", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 3.6-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ", 3.7-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна" 3.7.1-д "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах", Боловсрол шинжлэх ухааны яамны 2020 оны 3/1557 дугаар албан бичиг "Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем"-ийн [www.esis.edu.mn](http://www.esis.edu.mn) цахим системийг ашиглан бүртгэх тухай" гэсэн заалтуудыг мөрдөөгүй иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд хүүхэд өдрийн төлөвлөгөөг 38,100 хүүхэд өдрөөр батлагдаж гүйцэтгэлээр 25,172 хүүхэд өдөр буюу 66.1 хувьтай, улсын төсвөөс 1,145,876.9 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч гүйцэтгэлийн үнэлгээнд 4 дүгээр түвшинд 1 багш, 5 дугаар түвшинд 6 багш үнэлэгдсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>231,009,798.33</u></b>	<b><u>132,686,725.20</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	171,539,121.76	65,376,104.56
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	171,539,121.76	65,376,104.56
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	171,539,121.76	65,376,104.56
31211	Төрийн сангийн харилцах	171,539,121.76	65,376,104.56
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	656,466.57	56,110.64
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	656,466.57	56,110.64
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	500,000
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	-	500,000
34713	Цалингийн урьдчилгаа	-	500,000
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	58,814,210	66,754,510
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	58,814,210	66,754,510
35420	Аж ахуйн материал	58,814,210	64,126,610
35460	Хүнсний материал	-	2,627,900
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,310,733,551.66</u></b>	<b><u>1,272,956,877.57</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,310,733,551.66	1,272,956,877.57
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,300,733,551.66	1,262,956,877.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,388,934,325	1,388,934,325
39202	Хуримтлагдсан элэгдэл	(160,331,226.72)	(183,535,687.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	83,920,390.00	85,892,784.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,161,406.64)	(54,385,039.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,234,176	53,185,706
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,862,705.98)	(27,135,210.02)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	10,000,000	10,000,000
39301	Програм хангамж	1,375,000	1,375,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,375,000)	(1,375,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,000,000	10,000,000
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,541,743,349.99</u></b>	<b><u>1,405,643,602.77</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,541,743,349.99</u></b>	<b><u>1,405,643,602.77</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,541,743,349.99	1,405,643,602.77
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,541,743,349.99	1,405,643,602.77
51210	Өмнөх үеийн үр дүн	1,541,743,349.99	1,540,807,066.35
51220	Тайлант үеийн үр дүн	-	(135,163,463.58)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,541,743,349.99</u></b>	<b><u>1,405,643,602.77</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,049,850,822</b>	<b>1,057,477,424</b>

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>39,602,122</b>	<b>2,223,924</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	2,223,924
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,223,924
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	2,223,924
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	39,602,122	-
122001	Хандив тусламж /дотоод/	39,602,122	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,010,248,700</b>	<b>1,055,253,500</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	901,019,400	961,849,100
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	901,019,400	961,849,100
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	109,229,300	93,404,400
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	109,229,300	93,404,400
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>992,778,610.32</b>	<b>1,192,640,887.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>992,778,610.32</b>	<b>1,192,640,887.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	963,710,620.32	1,177,101,295.76
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	652,064,679.19	848,041,316.11
210101	Үндсэн цалин	652,064,679.19	510,359,528.78
210102	Нэмэгдэл	-	257,024,768.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	27,345,000
210104	Урамшуулал	-	53,312,019.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74,917,515.43	106,797,979.69
210201	Тэтгэврийн даатгал	74,917,515.43	72,607,831.97
210202	Тэтгэмжийн даатгал	-	8,464,866.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	5,076,860.87
210204	Ажилгүйдлийн даатгал	-	4,232,433.36
210205	Эрүүл мэндийн даатгал	-	16,415,987.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	83,197,310	73,664,808.18
210301	Гэрэл, цахилгаан	7,818,750	8,879,180.18
210302	Түлш, халаалт	72,833,960	51,278,828
210303	Цэвэр, бохир ус	2,544,600	13,506,800
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,682,515	11,575,500
210401	Бичиг хэрэг	18,232,050	6,233,250
210402	Тээвэр, шатахуун	5,490,955	3,891,350
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,959,510	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,450,900
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	85,293,700	75,804,780
210502	Хоол, хүнс	85,293,700	75,804,780
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	4,200,000
210604	Урсгал засвар	-	4,200,000
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	740,000	-
210702	Дотоод албан томилолт	740,000	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	4,114,697.33
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,114,697.33
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	40,814,900.70	52,902,214.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,811,711	11,157,050
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	580,850
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,003,189.70	41,164,314.45
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	29,067,990	15,539,591.82
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	29,067,990	15,539,591.82

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,067,990	15,539,591.82
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>57,072,211.68</b>	<b>(135,163,463.58)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>57,072,211.68</b>	<b>(135,163,463.58)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,010,248,700</b>	<b>1,055,253,500</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,010,248,700</b>	<b>1,055,253,500</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	901,019,400	961,849,100
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	901,019,400	961,849,100
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	109,229,300	93,404,400
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	109,229,300	93,404,400
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>962,728,536.46</b>	<b>1,161,416,517.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>962,728,536.46</b>	<b>1,161,416,517.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>933,660,546.46</b>	<b>1,145,876,925.38</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	649,223,428.46	853,813,939.87
210101	Үндсэн цалин	649,223,428.46	487,386,975.14
210102	Нэмэгдэл	-	278,619,707.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	27,475,000
210104	Урамшуулал	-	60,332,257.11
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	75,573,982	100,925,000
210201	Тэтгэврийн даатгал	75,573,982	68,635,100
210202	Тэтгэмжийн даатгал	-	8,075,300
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	4,039,000
210204	Ажилгүйдлийн даатгал	-	4,039,000
210205	Эрүүл мэндийн даатгал	-	16,136,600
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	78,901,310	73,664,808.18
210301	Гэрэл, цахилгаан	13,648,050	8,879,180.18
210302	Түлш, халаалт	62,708,660	51,278,828
210303	Цэвэр, бохир ус	2,544,600	13,506,800
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,574,565	-
210401	Бичиг хэрэг	1,124,100	-
210402	Тээвэр, шатахуун	5,024,205	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,426,260	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	85,293,700	78,432,680
210502	Хоол, хүнс	85,293,700	78,432,680
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,260,000	4,200,000
210604	Урсгал засвар	1,260,000	4,200,000
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	270,000	-
210702	Дотоод албан томилолт	270,000	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	4,114,697.33
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,114,697.33
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	33,563,561	30,725,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,563,561	22,855,500.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	7,870,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,067,990</b>	<b>15,539,591.82</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	29,067,990	15,539,591.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,067,990	15,539,591.82
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>47,520,163.54</b>	<b>(106,163,017.20)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	47,520,163.54	(106,163,017.20)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	124,018,958.22	171,539,121.76
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	171,539,121.76	65,376,104.56

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(ТӨГРӨГӨӨР)

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,484,671,138.31	1,484,671,138.31
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>1,484,671,138.31</b>	1,484,671,138.31
C07	Тайлант үеийн үр дүн	57,072,211.68	57,072,211.68
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,541,743,349.99</b>	1,541,743,349.99
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,541,743,349.99</b>	1,541,743,349.99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-936,283.64	-936,283.64
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>1,540,807,066.35</b>	1,540,807,066.35
D08	Тайлант үеийн үр дүн	-135,163,463.58	-135,163,463.58
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,405,643,602.77</b>	1,405,643,602.77

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(ТӨГРӨГӨӨР)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,194,600,700	1,145,876,925.38
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,194,600,700	1,145,876,925.38
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,194,600,700	1,145,876,925.38
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	868,550,200	853,813,939.87
210101	Үндсэн цалин	542,940,700	487,386,975.14
210102	Нэмэгдэл	295,919,900	278,619,707.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт		27,475,000
210104	Урамшуулал	29,689,600	60,332,257.11
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	108,017,800	100,925,000
210201	Тэтгэврийн даатгал	73,275,700	68,635,100
210202	Тэтгэмжийн даатгал	8,685,500	8,075,300
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,342,800	4,039,000
210204	Ажилгүйдлийн даатгал	4,342,800	4,039,000
210205	Эрүүл мэндийн даатгал	17,371,000	16,136,600
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	89,170,800	73,664,808.18
210301	Гэрэл, цахилгаан	8,970,000	8,879,180.18
210302	Түлш, халаалт	66,694,000	51,278,828
210303	Цэвэр, бохир ус	13,506,800	13,506,800
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	90,617,600	78,432,680

210502	Хоол, хүнс	90,617,600	78,432,680
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,233,600	4,200,000
210604	Урсгал засвар	4,233,600	4,200,000
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,114,700	4,114,697.33
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,114,700	4,114,697.33
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	29,896,000	30,725,800
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,855,500	22,855,500
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,040,500	7,870,300
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,194,600,700	1,039,713,908
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	969,324,900	961,849,100
131001	Улсын төсвөөс санхүүжих	969,324,900	961,849,100
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	93,404,400	77,864,808
132001	Орон нутгийн төсвөөс	93,404,400	77,864,808
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	131,871,400	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	131,871,400	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	171,539,121.76
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	65,376,104.56
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	30	30
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16
620003	Үйлчлэх ажилтан	13	13
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>30</b>	<b>30</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	16	16
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13	13

#### ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 73,834.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 54,800.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, үндсэн хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн нийт 6,744.8 мянган төгрөгийг зөрүүтэй тусгасан,
- Мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд 15,539.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлж тайланд санхүүжилтийн орлого бууруулан тусгасан,
- Тайлант оны хөрөнгийн элэгдлийг зардал, тайлант үеийн үр дүнг 17,180.3 мянган төгрөгөөр буруу илэрхийлсэн,
- Хөрөнгийн ашиглах жилийг буруу оруулснаар зарим хөрөнгөнд элэгдэл тооцоогүй, ашиглах жилийг хасах утгатай оруулж 14,399.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Өмнөх үеийн хуримтлагдсан элэгдлийг буруу тооцож 936.4 мянган төгрөгийн элэгдлийг өмнөх үр дүн дансны бичилтийг буруу илэрхийлсэн,

Залруулагдаагүй нийт 19,034.4 мянган төгрөгийн 4 зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшинг 13,417.2 мянган төгрөгөөс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 19,034.4 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 6,220.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 12,813.7 мянган төгрөгийн 3 өгсөн.

### **3.1 Төлбөрийн акт**

#### **3.1.1 Цалин, томилолтын зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Амралт цалин давхардсан, сахилгын арга хэмжээтэй албан хаагчид улирлын үр дүнгийн урамшуулал бодсон, мэргэжлийн зэргийн нэмэгдлийг тогтоолд заасан хувиас илүү, ур чадварыг нэмэгдлийг давхардуулсан, томилолтоор ажилласан хугацаанд хоолны мөнгийг давхардуулан олгосон зэрэг нийт 6,220,750 төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх;” 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг” хурмын 2-д “Төрийн үйлчилгээний албан хаагчийг мэргэжлийнхээ дагуу тухайн албан тушаал эрхэлж байх хугацаанд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг үндэслэн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно: “Заах аргач зэрэгт 10 хувиар”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй”, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын 2.1-д “Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно. 2.2-т “ Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараахь зардлаас бүрдэнэ:”, 2.2.1-д “унааны зардал;”, 2.2.2-т “байрны зардал;”, 2.2.3-т “хоолны зардал” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **3.2.1 Хүүхдийн ирцийн бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Боловсрол мэдээллийн esis.edu.mn системд илгээсэн 2025 оны 03-12 саруудын хүүхдийн ирцийн тоо мэдээг байгууллагын багш нарын өдөр тутамд хөтөлдөг “бүлгийн ирц бүртгэл”-ийн журналын тоотой тулгахад 6401 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; ” 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; ”16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”, БШУЯ-ны 2020 оны 3/1557 дугаар албан бчиг “Боловсролын салбарын

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

удирдлага мэдээллийн систем"-ийн [www.esis.edu.mn](http://www.esis.edu.mn) цахим системийг ашиглан бүртгэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн : Боловсролын мэдээллийн [esis.edu.mn](http://esis.edu.mn) цахим бүртгэлд тухай бүрд мэдээллийг үнэн зөв оруулж, ирцийн бүртгэлд тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэн ажиллах

### **3.2.2 Дотоод хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын А/04 тоот захирамжаар сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаагаар хязгаарлалт хийсэн өдрүүдэд 124 хүүхэд хүлээн авч хоолны зардал гаргасан, тайлант онд дотоод хяналтын багийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгасны ажлуудыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс өөр ажилд шилжсэн албан хаагчийн эцсийн тооцоо бодоогүй 3,076,044 төгрөгийн амралтын цалин олгосон нь дотоод хяналт сул байгаатай холбоотой байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 3.6-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ", 3.7-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна" 3.7.1-д "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах", 3.7.3--д "илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;" Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх;" 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн : Дотоод хяналтын төлөвлөгөөнд тусгасны дагуу хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, үр дүн тооцон ажиллах, холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрийг мөрдөн ажиллах

### **3.2.3 Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2025 оны 6-8 саруудын Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалингийн санг 6,197,743 төгрөгөөр дутуу, зарим багш ажилчдын ээлжийн амралттай хугацааг 17,06 кодоор 3,168,000 төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан нь Нийгмийн даатгалын ерэнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;" 32.2.3-т "нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх;" 32.2.-т нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх;" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн : Нийгмийн даатгалын газарт хүсэлт уламжилж 2025 оны 6-8 саруудын тайланг засварлан ажиллах

Дээрх ийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь

энэ хуулийн 20.2-т заасан ийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Булган сумын II цэцэрлэг	5	54,800.5	1	7,681.2	4	47,119.3	5	54,800.5	-	-	-	-
Дүн	5	54,800.5	1	7,681.2	4	47,119.3	5	54,800.5				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн баримт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны	Тоо	Дүн
Булган сумын II цэцэрлэг	4	19,034.4	1	6,220.7			3	12,813.7	-	-	-	-
Дүн	4	19,034.4	1	6,220.7	-	-	3	12,813.7	-	-	-	-

## ТАВ. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	-	1	-	-
НИЙТ			1	-	-	-	1	-	-